



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/16-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>  Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>  Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:ankhbayaro@audit.gov.mn">ankhbayaro@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1.АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	11
3.4.2 Авлага .....	11
3.4.3 Бараа материал.....	12
3.4.4 Үндсэн хөрөнгө .....	12
3.4.5 Өр төлбөр.....	13
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо .....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	19
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
4.6.1 Завсрын аудитын талаар.....	20
4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	20
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	20
5.1 Төлбөрийн акт.....	21
5.1 Албан шаардлага .....	21
5.3 Зөвлөмж .....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	22

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Ц.БАЯНБААТАР ТАНАА

2024.03.29 № 00А-2024/16-НА-СТА-ТТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сумын ИТХ-ын “Цагааннуур сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 104 дүгээр тогтоолоор тайлант онд 1,192,748.9 мянган төгрөгийн татварын орлого, 21,500.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **1,214,248.9** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **1,803,405.5** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 1.5 дахин давуулан биелүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

ЗДТГ нь өөрийн үйл ажиллагааны орлого болох түрээсийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хэт багаар буюу 500.0 мянган төгрөгөөр

төлөвлөж батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр төлөвлөгөөнөөс давсан 5,313.2 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Цагааннуур сумын Засаг дарга нь тайлант онд 17 зорилт, 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.6 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>851,336.3</b>	<b>1,322,461.1</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	636,085.2	1,067,660.5
33	АВЛАГА	144,438.6	175,828.0
35	БАРАА МАТЕРИАЛ	70,812.5	78,972.6
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,577,167.9</b>	<b>9,823,642.2</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,577,167.9	9,823,642.2
39200	Биет хөрөнгө	8,500,414.9	9,748,263.5
39300	Биет бус хөрөнгө	76,753.0	75,378.8
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>9,428,504.2</b>	<b>11,146,103.3</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>68,701.4</b>	<b>2,367.9</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	68,701.4	2,367.9
41300	Өглөг	68,701.4	2,367.9
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>9,359,802.8</b>	<b>11,143,735.4</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	9,359,802.8	11,143,735.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,588,489.6	1,588,489.6
51200	Хуримтлагдсан үр дүн	7,052,785.5	8,836,718.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	718,527.7	718,527.7
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>9,428,504.2</b>	<b>11,146,103.3</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,606,940.0</b>	<b>4,716,795.2</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,029,273.3	1,746,992.9
110	Орлогын албан татвар	409,280.1	692,290.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	409,280.1	723,549.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-31,258.7
113	Хөрөнгийн албан татвар	217,810.7	241,401.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	402,182.5	813,300.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	872,880.9	2,050,724.8
120	Нийтлэг татварын бус орлого	872,880.9	2,050,724.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,704,785.8	919,077.5
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,245,838.2</b>	<b>2,594,426.2</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,245,838.2	2,594,426.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,800,678.5	2,554,639.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	515,909.3	707,506.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,463.8	88,373.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	360,851.7	70,799.5
2104	Хангамж, бараа материалын зардал	51,441.4	68,892.5
2105	Нормативт зардал	559.8	2,238.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	167,599.8	394,723.6
2107	Томилолт, зочны зардал	14,036.2	16,500.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,373.0	485,416.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	598,443.4	720,188.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,445,159.7	39,787.2
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,361,101.8</b>	<b>2,122,369.0</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,270,337.7</b>	<b>402,781.8</b>

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,909,235.9	1,719,587.3
----	---	--------------	-------------

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,270,831.2	14,270,831.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,652.8	-7,652.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,263,178.4	14,263,178.4
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	45,672.0	45,672.0
9	Тайлант үеийн үр дүн	-4,909,235.9	-4,909,235.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,399,614.4	9,399,614.4
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,399,614.4	9,399,614.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	24,533.7	24,533.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,424,148.1	9,424,148.1
19	Тайлант үеийн үр дүн	1,719,587.3	1,719,587.3
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,143,735.4	11,143,735.4

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,910,349.9	2,849,691.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,029,273.3	1,746,992.9
110	Орлогын албан татвар	409,280.1	692,290.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	409,280.1	723,549.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-31,258.7
113	Хөрөнгийн албан татвар	217,810.7	241,401.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	402,182.5	813,300.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	263,583.6	379,837.1
1181	Газрын төлбөр	49,273.5	327,937.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	89,325.3	105,526.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	136,479.2	183,621.3
120	Нийтлэг татварын бус орлого	136,479.2	183,621.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,744,597.4	919,077.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,676,552.1	1,606,499.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,676,552.1	1,606,499.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,191,576.7	1,566,711.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,716.5	708,699.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,668.4	89,168.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	360,851.7	70,799.5
2104	Хангамж, бараа материалын зардал	50,416.0	65,142.5
2105	Нормативт зардал	559.8	2,238.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,715.1	29,839.1
2107	Томилолт, зочны зардал	14,036.2	16,500.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,775.4	485,416.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,837.6	98,907.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,484,975.4	39,787.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,233,797.8	1,243,192.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,042,856.0	723,217.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,042,856.0	723,217.4

2200	Дотоод эх үүсвэрээр	1,042,856.0	723,217.4
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-1,042,856.0</b>	<b>-723,217.4</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>0.0</b>	<b>-88,400.0</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>0.0</b>	<b>88,400.0</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>190,941.8</b>	<b>431,575.3</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	445,143.4	636,085.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	636,085.2	1,067,660.5

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,064,203.3</b>	<b>2,366,815.9</b>	<b>-697,387.4</b>	<b>77.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,602,708.0</b>	<b>1,573,822.4</b>	<b>-28,885.6</b>	<b>98.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,568,038.7</b>	<b>1,539,479.8</b>	<b>-28,558.9</b>	<b>98.2</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,081.3	698,009.2	-3,072.1	99.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,811.0	88,007.1	-803.9	99.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	481,665.2	459,816.1	-21,849.1	95.5
2104	Хангамж, бараа материалын зардал	58,393.4	58,131.6	-261.8	99.6
2105	Нормативт зардал	643.1	0.0	-643.1	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	93,381.6	93,372.0	-9.6	100.0
2107	Томилолт, зочны зардал	14,067.1	13,956.4	-110.7	99.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,453.7	47,891.8	-1,561.9	96.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,542.3	80,295.6	-246.7	99.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,669.3</b>	<b>34,342.6</b>	<b>-326.7</b>	<b>99.1</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,669.3	34,342.6	-326.7	99.1
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,335,779.8</b>	<b>704,593.5</b>	<b>-631,186.3</b>	<b>52.7</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>125,715.5</b>	<b>88,400.0</b>	<b>-37,315.5</b>	<b>70.3</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,064,203.3</b>	<b>2,444,006.5</b>	<b>-620,196.8</b>	<b>79.8</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,291,197.9	2,314,127.9	22,930.0	101.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	647,289.9	129,878.6	-517,411.3	20.1
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	125,715.5	0.0	-125,715.5	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	189,398.0	189,398.0	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	266,588.6	266,588.6	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>81.0</b>	<b>81.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.0	3.0	0.0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	39.0	39.0	0.0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39.0	39.0	0.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>54,820.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>54,820.70</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,855.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,690.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,161.20
2104	Хангамж, бараа материалын зардал	7,011.00
2105	Нормативт зардал	2,238.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,599.40
2107	Томилолт, зочны зардал	2,544.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,612.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,964.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,444.60
3133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,520.20
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>54,820.70</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,820.70
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагааннуур сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Сумын Засаг даргыг үйл ажиллагаагаа явуулахад нь мэргэшлийн зөвлөгөө мэдээллээр хангах, зөвлөн туслах, төрийн үйлчилгээний тасралтгүй хэвийн жигд үйлчилгээг хангаж иргэдэд тэгш хүртээмжтэй үйлчилж ажиллана” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах
- Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Тухайн шатны ИТХ-ын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх;

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн зарим албан хаагчийн цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

2023 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цагааннуур сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Цагааннуур сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,717,599.1 мянган төгрөгөөр буюу 18.2 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	636,085.20	1,067,660.50	431,575.30
Авлага	144,438.60	175,828.00	31,389.40
Бараа материал	70,812.50	78,972.60	8,160.10
Үндсэн хөрөнгө	8,577,167.90	9,823,642.20	1,246,474.30
<b>Нийт хөрөнгө</b>	<b>9,428,504.20</b>	<b>11,146,103.30</b>	<b>1,717,599.10</b>
Өр төлбөр	28,889.80	2,367.90	-26,521.90
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,399,614.40	11,143,735.40	1,744,121.00
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>9,428,504.20</b>	<b>11,146,103.30</b>	<b>1,717,599.10</b>

*Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсныг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,067,660.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 190,941.8 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	636,085.20	1,067,660.50	431,575.30
<b>Төгрөг</b>	<b>636,085.20</b>	<b>1,067,660.50</b>	<b>431,575.30</b>
Төрийн сангийн харилцах	636,085.20	1,067,660.50	431,575.30
<b>Дүн</b>	<b>636,085.20</b>	<b>1,067,660.50</b>	<b>431,575.30</b>

*Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 801,071.9 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 192,497.5 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 74,091.1 мянган төгрөг тус тус байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 175,828.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 31,389.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	------------------------

Ажиллагчтай холбогдсон авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага	2,680.4	4,119.9	1,439.5
Байгууллагаас авах авлага	57.3	57.3	0.0
Хувь хүмүүсээс авах авлага	141,700.9	171,650.8	29,949.9
<b>Дүн</b>	<b>144,438.6</b>	<b>175,828.00</b>	<b>31,389.4</b>

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт авлагын үлдэгдлийн 99.9 хувь буюу 175,770.7 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл эзэлж байна. Үүнээс 47,887.4 мянган төгрөг буюу 27.2 хувь нь 2011-2019 оны хооронд олгосон хугацаа хэтэрсэн зээлийн авлага байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 78,972.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,160.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>570.0</b>	<b>1,160.0</b>	<b>590.0</b>
Тусгай зориулалттай материал	570.0	1,160.0	590.0
Эм боох материал	0.0	0.0	0.0
<b>Хангамжийн материал</b>	<b>70,242.5</b>	<b>77,812.6</b>	<b>7,570.1</b>
Бичиг хэргийн материал	0.0	0.0	0.0
Аж ахуйн материал	70,027.1	77,597.2	7,570.1
Сэлбэг хэрэгсэл	0.0	0.0	0.0
Түлш, шатах тослох материал	0.0	0.0	0.0
Хүнсний материал	0.0	0.0	0.0
Бусад хангамжийн материал	215.4	215.4	0.0
<b>Мал амьтад</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>Дүн</b>	<b>70,812.5</b>	<b>78,972.6</b>	<b>8,160.1</b>

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 8,160.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 562,883.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 10,000.0 мянган төгрөгийн бараа материал хүлээн авсан болон 222,490.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 339,709.0 мянган төгрөгийг шилжүүлэн, 2,523.1 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 9,823,642.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,246,474.3 мянган төгрөгөөр байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>8,500,414.9</b>	<b>9,748,263.4</b>	<b>1,247,848.5</b>
Барилга, байгууламж, орон сууц	5,643,478.3	5,670,782.8	27,304.5
Авто-тээврийн хэрэгсэл	91,824.5	239,787.9	147,963.4

Машин тоног төхөөрөмж(компьютер)	223,285.0	268,013.7	44,728.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	34,446.1	42,278.7	7,832.6
Дуусаагүй барилга байгууламж	63,072.8	143,183.2	80,110.4
Номын фонд	0.0	0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	2,444,308.2	3,384,217.1	939,908.9
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>76,753.0</b>	<b>75,378.8</b>	<b>-1,374.2</b>
Программ хангамж	0.0	0.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	76,753.0	75,378.8	-1,374.2
<b>Дүн</b>	<b>8,577,167.9</b>	<b>9,823,642.2</b>	<b>1,246,474.3</b>

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 1,246,474.3 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 18,623.9 мянган төгрөгийн хөрөнгө /4,983.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 13,640.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө/ худалдан авсан,
- Хөдөө аж ахуйн яамнаас 192,847.5 мянган төгрөгийн хүлэмж нөөцийн сав, аймгийн БОАЖГ-аас 52,318.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр хүлээн авсан,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн сум доторх хатуу хучилттай 914,236.6 мянган төгрөгийн 1.5 км зам орлогод авсан,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Хонхор цэвэр усны шугам”-ын 223,100.0 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авсан,
- Ойн ангиас 7,321.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, ЗДТГ-аас 33,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 7,209.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж зэрэг нийт 47,531.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан,
- Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй ОНХС-аар хийгдсэн 63,072.8 мянган төгрөгийн 2 хөрөнгө оруулалтыг улсын комиссоор хүлээн авч шилжүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 28,889.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,367.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 26,521.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	1,988.2	0.0	-1,988.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	24,533.7	0.0	-24,533.7
Байгууллагад төлөх өглөг	2,367.9	2,367.9	0.0
<b>Дүн</b>	<b>28,889.8</b>	<b>2,367.9</b>	<b>-26,521.9</b>

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст өр төлбөр данс үлдэгдэл нь 26,521.9 мянган төгрөгөөр буурсан нь Спорт цогцолборын халаалтын зардалтай холбоотой 24,533.7 мянган төгрөгийн өглөгийг барагдуулснаас шалтгаалсан байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 9,359,802.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,911,028.4 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,588,489.6	1,588,489.6	0.0
Хуримтлагдсан үр дүн	7,092,597.1	8,836,718.1	1,744,121.0
Өмнөх үеийн үр дүн	12,001,833.0	7,117,130.8	-4,884,702.2
Тайлант үеийн үр дүн	-4,909,235.9	1,719,587.3	6,628,823.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	718,527.7	718,527.7	0.0
<b>Дүн</b>	<b>9,399,614.4</b>	<b>11,143,735.4</b>	<b>1,744,121.0</b>

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл урьд оноос 1,744,121.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Цагааннуур сумын ИТХ-ын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 104 дүгээр тогтоолоор 1,237,748.9 мянган төгрөгийн татварын орлого, 21,500.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,834,664.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 45.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

#### Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>1,237,748.9</b>	<b>1,778,251.6</b>	<b>540,502.7</b>	<b>143.7</b>
Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	434,566.1	591,504.6	156,938.5	136.1
Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	74,700.0	87,562.6	12,862.6	117.2
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	44,500.0	46,385.2	1,885.2	104.2
Хөрөнгийн орлого	44,100.0	42,928.4	-1,171.6	97.3
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	1,200.0	1,554.0	354.0	129.5
Бууны албан татвар	1,500.0	1,848.0	348.0	123.2
Малд ногдуулах албан татвар	350,000.0	193,168.7	-156,831.3	55.2
Улсын тэмдэгтийн хураамж	1,100.0	1,872.9	772.9	170.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	89,125.0	375,392.5	286,267.5	421.2

Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,000.0	2,571.7	-1,428.3	64.3
Газрын төлбөр	63,384.4	61,164.5	-2,219.9	96.5
Газрын дуудлага худалдаа	31,500.0	266,772.7	235,272.7	846.9
Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр	96,273.4	103,204.7	6,931.3	107.2
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж		428.0	428.0	
Байгалийн ургамал ашигласны төлбөр	1,800.0	1,893.2	93.2	105.2
<b>Татварын бус орлого</b>	<b>21,500.0</b>	<b>56,412.6</b>	<b>34,912.6</b>	<b>262.4</b>
Хүү, торгуулийн орлого	20,000.0	53,383.7	33,383.7	266.9
Бусад орлого	1,500.0	3,028.8	1,528.8	201.9
<b>Нийт дүн</b>	<b>1,259,248.9</b>	<b>1,834,664.2</b>	<b>575,415.3</b>	<b>145.7</b>

Эх сурвалж: Цагааннуур сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

#### Давж биелсэн орлогууд:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 156,938.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2023 оны 7 дугаар сараас төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 286,267.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь Шаамар сумаас Цагааннуур сум хүртэлх хар зам тавьж байгаатай холбоотой хайрганы карьер ашигласны төлбөр төвлөрснөөс шалтгаалсан,
- Газрын дуудлага худалдааны орлого 235,272.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь хураагдсан модны болон үйлчилгээ явуулах газрын дуудлага худалдааны орлого нэмэгдсэнээс шалтгаалсан,
- Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр 6,931.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь сумын бүс нутагт мод бэлтгэл өссөнөөс шалтгаалсан байна.

#### Тасарсан орлогууд:

- Малд ногдуулах албан татварын орлого 156,831.3 мянган төгрөгөөр тасарсан нь тооцсон татварыг төвлөрүүлж чадахгүй байгаагаас шалтгаалсан,
- Газрын төлбөрийн орлого 2,219.9 мянган төгрөгөөр тасарсан нь 2023 онд нэхэмжлэл үүсгэсэн 2 аж ахуйн нэгжийн хооронд эрх шилжүүлэх явцад маргаан үүссэнээс шалтгаалсан байна.

### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 148155.3 мянган төгрөгөөр, татварын болон татварын бус орлогоос 669,444.4 мянган төгрөгөөр, өөрийн үйл ажиллагааны орлогоос 500.0 мянган төгрөгөөр зэрэг нийт орлого, зарлагыг 818,599.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 78 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 1,151,682.8 мянган төгрөгөөр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 355,638.0 мянган төгрөгөөр, төсөвт газрын өөрийн орлогыг 58,414.0 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 523,138.3 мянган төгрөгөөр, урьд

оны үлдэгдлээс 672,480.9 мянган төгрөг, ХХС-ийн орлогоос 31,022.3 мянган төгрөг зэрэг нийт **2,792,376.3** мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 104 дүгээр тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг нэмэгдүүлж **3,064,203.3** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

#### Эх үүсвэрийн өөрчлөлт:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 7,566.1 мянган төгрөгөөр,
- ХХОАТ-ын орлогыг 53,000.0 мянган төгрөгөөр,
- Хувь хүнээс суутгасан орлогын албан татварыг 2,000.0 мянган төгрөгөөр,
- Газрын дуудлага худалдааны орлогыг 16,500.0 мянган төгрөгөөр,
- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 6,588.2 мянган төгрөгөөр,
- Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 77,551.9 мянган төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 106,408.6 мянган төгрөгөөр,
- Урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх дүнг 18,712.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хөрөнгө борлуулсны албан татварыг 8,900.0 мянган төгрөгөөр,
- Улсын тэмдэгтийн хураамжийг 2,600.0 мянган төгрөгөөр,
- Газрын төлбөрийн орлогыг 5,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан,

#### Төсвийн зарлагын өөрчлөлт:

- ИТХ-ын урсгал зардлыг 17,437.2 мянган төгрөгөөр,
- ЗДТГ-ын урсгал зардлыг 85,897.0 мянган төгрөгөөр,
- Ойн ангийн тогтмол зардлыг 10,426.7 мянган төгрөгөөр,
- Соёлын төвийн тогтмол зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр,
- ЕБС-ийн тогтмол зардлыг 16,183.3 мянган төгрөгөөр,
- ЭМТ-ийн тогтмол зардлыг 11,762.0 мянган төгрөгөөр,
- ОНХС-г 120,620.8 мянган төгрөгөөр,
- ОНХО-ын зардлыг 4,500.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 433,189.9 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 629,546.9 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 691,193.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 31,022.3 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 1,214,248.9 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 65,002.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **3,064,203.3** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 234,709.9 мянган төгрөгийг аймгийн төсвийн санхүүгийн дэмжлэгээс, 629,546.9 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 1,803,405.5 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 65,087.4 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **2,732,749.7** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,366,815.9** мянган төгрөг буюу **77.2** хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 3,072.1 мянган төгрөгөөр,

байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 21,849.1 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийг 37,315.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 23 төсөл, арга хэмжээнд 1,265,639.8 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 852,951.0 мянган төгрөгийн санхүүжилт олгон, 192,497.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь зураг төсөв хийгдээгүй 1 төсөл, арга хэмжээ болон малын тоо толгойн албан татварын орлогын 41.7 хувь нь буюу 80,526.6 сая төгрөгийн орлого тайлант оны 4-р улиралд орсноор бүтээн байгуулалтын 7 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй зэргээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 11,702.2 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс 2,352.9 мянган төгрөг, ГБХЗХГ-аас 600.0 мянган төгрөг, аймгийн БОАЖГ-аас 6,000.0 мянган төгрөг, Ойн газраас 17,900.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас 300.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,965.5 мянган төгрөг зэрэг нийт 54,820.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж урсгал зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 10. Худалдан авах ажиллагаа

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			Шууд худалдан авалт		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХС	8	647,357.6	1	9,835.5	4	223,300.0	3	414,222.1
Сумын ОНХО	4	39,640.0	4	39,640.0	-	-	-	-

Эх сурвалж: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

---

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагааннуур сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Байгууллагын үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 67 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,825,391.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу **27,380.9** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,594,426.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон **38,916.4** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Цагааннуур сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагад ном хэвлэлийн зардал, дүрэмт хувцас худалдаж авахгүй байх, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байхад хяналт тавьж ажилласан,
- Албан хэрэг хөтлөлтийг цахимжуулж бичиг хэргийн зардлыг бууруулсан,

- Хөрөнгө оруулалтаар авто машин худалдан аваагүй,
- Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол тэмдэглэлт өдрийг зохион байгуулаагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

##### Хүснэгт 11. Шилэн данс

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	181	150	31	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	183	181	2	
3	Засаг даргын Тамгын газар	183	181	2	
4	Орхон бүсийн ойн анги	183	182	1	
	<b>Нийт дүн</b>	<b>730</b>	<b>694</b>	<b>36</b>	

Эх сурвалж: [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)

ТТЗ-ийн түвшинд нийт мэдээлбэл зохих 730 мэдээллээс 694 мэдээллийг хугацаанд нь, **36** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

#### 4.5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1.Сумын ЗДТГ нь шууд худалдан авах босго үнээс давсан **33,500.0** мянган төгрөгийн тавилгын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны

журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн 2: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

#### 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.6.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	26,282.6	5	26,282.6	100.0
Зөвлөмж	1	895.5	1	895.5	100.0
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>27,178.1</b>	<b>6</b>	<b>27,178.1</b>	<b>100.0</b>

#### 4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **8,640.0** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 6,735.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1,905.0 мянган төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.1 Төлбөрийн акт

1. Сумын ЗДТГ-ын 2 албан хаагчийн илүү цагийн нэмэгдлийг 765.0 мянган төгрөгөөр, 1 албан хаагчийн хавсран ажилласны нэмэгдлийг 287.0 мянган төгрөгөөр, 9 албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг 30 хувиар тооцож, 5,683.0 мянган төгрөг зэрэг нийт **6,735.0** мянган төгрөгийн цалинг илүү тооцож, олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан *“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”*-ын 3.3 дахь *“Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна...”*, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан *“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”*-ын 4 дэх *“Орон нутагт ажилласны нэмэгдлийг захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар бодож орон нутгийн болон улсын төсвөөс сар бүр олгоно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## 5.1 Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс гадаад томилолтын зардалд арга хэмжээ хооронд зориулалт бусаар **1,905.0** мянган төгрөгийг зарцуулж, санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан *“Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”*-ын 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтууд болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан *“Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”*-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай бол төсөвт зохицуулалт хийлгэх албан шаардлага хүргүүлэх.

## 5.3 Зөвлөмж

### 1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 68 нэр төрлийн

ИТХ-3, ЗДТГ-54, Ойн анги-11/ бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	2	6,735.0	1	6,735.0								
ЗДНХ	2	1,905.0			1	1,905.0	1					
<b>ТТЗ-ийн Дүн</b>	<b>4</b>	<b>8,640.0</b>	<b>1</b>	<b>6,735.0</b>	<b>1</b>	<b>1,905.0</b>	<b>1</b>					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 36 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1						1	
<b>Дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шууд худалдан авах босго үнээс давсан шатахууны худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлаагүй	1	28,438.5					1	28,438.5
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>28,438.5</b>					<b>1</b>	<b>28,438.5</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>28,438.5</b>					<b>2</b>	<b>28,438.5</b>